

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар

Нэгжийн нэр:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс

Албан тушаалын нэр:

Агентлагийн хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Хэнтий аймаг, Хэрлэн сум, 3-р баг, Залуучуудын гудамж - 01

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомж, тогтоол, шийдвэр, бодлогын баримт бичиг, төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, санал дүгнэлт, зөвлөмж боловсруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн даргын өмнө хариуцна.

<u>Албан тушаалын зорилт:</u>			
<p>1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлага албан хаагчдыг зөвлөмжөөр хангах, арга зүйн зөвлөмжөөр хангаж, дэмжлэг үзүүлэх</p> <p>2.Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг мэдээлж тайлагнах, арга зүйн зөвлөмжөөр ханган, хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн үр дүнг сайжруулах</p> <p>3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм журам стандартыг хэрэгжүүлэх.</p>			
Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Хуралдааны тэмдэглэл, албан даалгаврын хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, хууль, журмын дагуу тайлагнах;	Гүйцэтгэл, явц, үр дүнгийн дүгнэлт гарсан байх.	Т, Г, Х
	2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлтийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хууль, журмын дагуу тайлагнах;	Гүйцэтгэл, явц, үр дүнгийн дүгнэлт гарсан байх.	Т, Г, Х
	3.Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг Засгийн газрын цахим мэдээлийн сан www.unelgee.gov.mn программд оруулж баталгаажуулан, хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэн, хэрэгжилт,	Гүйцэтгэл, явц, үр дүнгийн дүгнэлт гарсан байх.	Т, Г, Х

	явц, үр дүнг иргэд олон нийтэд сурталчилах, мэдээлэх;		
	4.Салбарын сайд, аймгийн Засаг даргын хооронд байгуулсан гэрээг хяналтанд авч хэрэгжилтийг хангуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;	Гүйцэтгэл, явц, үр дүнгийн дүгнэлт гарсан байх.	Т, Г, Х
	5.Засгийн газрын тогтоолоор батлагдсан Үндэсний хөтөлбөрийг хяналтанд авч хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох яамдуудад хүргүүлэх;	Гүйцэтгэл, явц, үр дүнгийн дүгнэлт гарсан байх.	Т, Г, Х
	6.Аймгийн засаглалын болон эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж хууль, журмын дагуу тайлагнах;	Гүйцэтгэл, явц, үр дүнгийн дүгнэлт гарсан байх.	Т, Г, Х
	7.Гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, гаргасан зөвлөмжийг холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэх;	Гүйцэтгэл, явц, үр дүнгийн дүгнэлт гарсан байх.	Т, Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1.Хяналт-шинжилгээ, үнэлгээг төлөвлөгөөний дагуу хийж, холбогдох хэлтэс, агентлаг, сумдуудад зөвлөмж, дүгнэлт гаргаж хүргүүлэн, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих;	Зөвлөмж гарган холбогдох газруудад хүргүүлсэн байх.	Г, Х
	2.Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн зөвлөмжийг холбогдох хэлтэс агентлагуудад хүргүүлэх;		Г, Х
	3.Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагаанд иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын оролцоог ханган иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийсэн зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх;	Зөвлөмж гарган холбогдох газруудад хүргүүлсэн байх.	Г, Х

	4.Аймгийн Засаг даргын захирамж болон Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгаварын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж удирдлагуудад танилцуулах;	Зөвлөмж гарган холбогдох газруудад хүргүүлсэн байх.	Г, Х
	5.Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тайлагнах.	Зөвлөмж гарган холбогдох газруудад хүргүүлсэн байх.	Г, Х
3 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль, ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмыг чанд баримталж, хууль тогтоомжоор олгогдсон эрх, үүргээ шударгаар хэрэгжүүлж, хүнд суртал, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, төрийн үйлчилгээг соёлтой, шуурхай хүргэх;	Ёс зүйн зөрчил гаргаагүй байна.	Г, Т, Х
	2.Байгууллагын болон өөрийн үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж ажиллах;	Үйл ажиллагааны ил тод байдал хангагдсан байна.	Г
	3.Хэлтсийн даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж, тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө бүрэн хэрэгжсэн байна.	Г
	4.Хугацаатай бичгийн хариуг цаг хугацаанд нь хүргүүлэх, архив, албан хэрэг хөтлөлтийн журам, баримт бичгийн стандартыг мөрдөх;	Хугацаатай бичгийн хариу хүргэгдэж, журам, стандарт хэрэгжсэн байна.	Г, Т, Х
	5.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар хэрэгжсэн байна.	Г
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.	
Мэргэжил	Эрх зүй /042/, эдийн засаг /0311/, менежмент ба удирдахуй /0413/, боловсрол /011/.	
Мэргэшил	Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр сургалтанд хамрагдсан бол давуу тал болно.	
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээлэл цуглуулах, боловсруулах, харьцуулалт хийх; - нэгтгэж дүгнэх, санал, зөвлөмж боловсруулах; - гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах; - баримт бичигт дүн шинжилгээ хийх, дүгнэлт өгөх чадвартай байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах; - шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх; - өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх; - аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх; - төрийн албан хаагчийн ёс зүйн хэм, хэмжээг сахих; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх; - хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх; - бүтээлч, санаачлагатай ажиллах; - бусад.
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бие биеэ дэмждэг байх; - багийн хамт олны дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх; - багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - хамт олонч сэтгэлгээтэй, эерэг уур амьсгалыг дэмждэг байх; - нээлттэй, шударга байх; - бусад.
	Бусад	<ul style="list-style-type: none"> - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - зарчимч, тууштай, ажил хэрэгч байх; - шинэ санал, санаачилга, бүтээлч хандлагатай байх; - хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх; - компьютерийн хэрэглээний програм, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;

		<ul style="list-style-type: none"> - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулгын чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх;
--	--	---

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Байхгүй.

Бусад харилцах субъект:

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга;
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба;
- Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар;
- Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төрийн бусад байгууллагууд;
- Иргэн, хуулийн этгээд.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ
УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ж.ГАНТУЛГА
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ
Шийдвэрийн огноо:
Дугаар:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан

Байгууллагын нэр:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

Дугаар:.....

ДАРГА

Ж.ГАНБААТАР

20... оны ... дугаар сарын ... -ны өдөр

-----oOo-----

